



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ-2018



Улаанбаатар хот  
2019 он

## АГУУЛГА

1.Боловсруулах үйлдвэрлэл.....	3
2.Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл.....	4
3.Хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэл.....	6
4. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт.....	7

## ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Нийт үйлдвэрлэл гэж тайлант хугацаанд шинээр үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний нийт дүн (тухайн оны үнээр)-г хэлнэ.

Бүтээгдэхүүний борлуулалт гэж тайлант хугацаанд худалдсан буюу бусдад зориулж гүйцэтгэсэн ажил үйлчилгээг хэлнэ. Нийт борлуулалтад тухайн үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн ажил үйлчилгээний борлуулалтад орно. Хэрэв захиалагч бүтээгдэхүүнийхээ төлбөрийг урьдчилан төлсөн бол уг бүтээгдэхүүнийг борлуулагдсан гэж үзнэ.

Аж үйлдвэрийн борлуулалт зөвхөн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг хамруулна. Энд үйлдвэрлэлийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээ, үндсэн хөрөнгө, түүхий эд материал зэргийн худалдан борлуулсан хэмжээг хамруулахгүй.

Бүтээгдэхүүн гэж зах зээлд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй бэлэн бус бүтээгдэхүүнийг хэлнэ.

Үндсэн үнэ аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд гарсан зардал, ашгаа тооцон багтаасан үнийг үндсэн үнэ гэнэ. Үндсэн үнэд татварыг оруулж тооцохгүй ба татаасыг оруулж тооцно.

## БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ



2018 оны жилийн эцсийн байдлаар статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй 1434 аж үйлдвэрийн газруудын 512 (35.7%) нь үйл ажиллагаа явуулж байна. 2018 онд аж үйлдвэрийн салбарын албан ёсны мэдээнд хамрагдсан үйлдвэрүүд 489530.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Үүнээс мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 78038.3 сая төгрөг (15.9%), сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 139097.4 сая төгрөг (28.4%), үр тариа гурил, цардуул малын тэжээлийн үйлдвэрлэлт 132067.4 сая төгрөг (27%) хувийг, хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 57218.5 сая төгрөг (11.7%), архи ус ундаа үйлдвэрлэл 48330.6 сая төгрөг (9.9%) байна. Тайлант хугацаанд 34777.9 сая төгрөгийн хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэсэнээс 6553.4 (18.8%) сая төгрөгийн хувцас, 16802.6(48.3%) сая төгрөгийн химийн бүтээгдэхүүн, 283.6(0.8%) сая төгрөгийн резинен болон хуванцар бүтээгдэхүүн, 8783.3(25.3%) сая төгрөгийн төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл, 2125.5 (6.1%) сая төгрөгийн машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл, 229.4 (0.7%) сая төгрөгийн мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.

Хүснэгт 1. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сая төгрөгөөр

Салбар	2017	2018	$\frac{2018}{2017}$ %
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>311308.80</b>	<b>489530.1</b>	<b>157.2</b>
<b>Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл</b>	<b>289597.90</b>	<b>454752.2</b>	<b>157.0</b>
Маж, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	30417.00	78038.3	2.5 дахин
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	89811.90	139097.4	154.9
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	84105.40	132067.4	157.0
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	46652.70	57218.5	122.6
Архи, ус, ундаа үйлдвэрлэл	38610.90	48330.6	125.2
<b>Хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэл</b>	<b>21710.90</b>	<b>34777.9</b>	<b>160.2</b>
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	5835.80	6553.4	112.3
Мод, модон эдлэл	31.6	0	0.0
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	10998.80	16802.6	152.8
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	219.9	283.6	129.0
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	2358.60	8783.3	3.7 дахин
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	2051.00	2125.5	103.6
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	215.1	229.4	106.6

2018 онд нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 454752.2 (92.9%) сая төгрөгийг хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 34777.9 (7.1%) сая төгрөгийг хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэл эзэлж байна. Тайлант онд дүүргийн хүнсний үйлдвэрүүд 454752.2 сая төгрөгийн

бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 165154.3 (57%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний 78038.3 (17.2%) сая төгрөгийг мах махан бүтээгдэхүүн, 139097.4 (30.6%) сая төгрөгийг сүү, сүүн бүтээгдэхүүн, 132067.4 (29%) сая төгрөгийг үр тарианы гурил, малын тэжээл, 57218.5 (12.6%) сая төгрөгийг хүнсний бусад бүтээгдэхүүн, 48330.6 (10.6%) сая төгрөгийг архи ус ундаа тус тус эзэлж байна.


Зураг 1. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сая төгрөгөөр



### ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг үйлдвэрийн газрууд 2018 онд нийт 15.5 мян.тн мах махан бүтээгдэхүүн, 27163.9 мян. л,410 тн сүү сүүн бүтээгдэхүүн, 560.6 тн гурил, гурилан бүтээгдэхүүн, 20823.6 мян.л архи ус ундаа тус тус үйлдвэрлэсэн байна.


Зураг 2. Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар, хувиар



### Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл

2018 онд мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрүүд 78038.3 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 47621.3 (2.5 дахин) сая төгрөгөөр өссөн байна. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрүүд 2018 онд 13.1 мян.тонн мах бэлтгэсэн нь өмнөх оноос 8.4 ( 2.7 дахин) мян.тноор, 2016 оноос 8.8 (3 дахин) мян.тонноор өссөн байна. Харин 2.4 мян.тн хيامны төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 0.2(7.6%) мян.тн-оор буурсан байна.

Зураг 3. Бэлтгэсэн мах, мянган тонноор




### Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

2018 онд сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрүүд 139097.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 49285.5 (54.9%) сая төгрөгөөр өссөн байна. Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрүүд 2018 онд 18236.6 мян.л боловсруулсан шингэн сүү үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 2070.9 (12.8%) мян.л-ээр, 8927.3 мян.л тараг үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 2345.8 (35.6%) мян.л-ээр, 130 тн ааруул үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 10 (8.3%) тн-оор, 170 тн өтгөн цөцгий үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 20 (13.3%) тн-оор тус тус өссөн байна. Харин 110 тн цөцгийн тос үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 10 тн-оор (8.3%) буурчээ.

### Гурил гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл

2018 онд гурил гурилан бүтээгдэхүүний үйлдвэрүүд 132067.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 47962 (57%) сая төгрөгөөр өссөн байна. 2018 онд гурил гурилан бүтээгдэхүүний үйлдвэрүүд 46.7 мян.тн дээд гурил үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 19.3 (70.4%) мян.тн-оор, 59.2 мян.тн гурил I зэрэг үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 15.7 (36.0%) мян.тн-оор, 8.6 мян.тн гурил II зэрэг үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 3.2 (59.2%) мян.тн-оор, 4.5 мян.тн нарийн боов үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 900 (25.0%) тонноор, 7.5 мян.тн гоймон үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 600 (8.6%) тонноор, 14.1 мян.тн талх үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 2.3 (19.4%) мян.тн-оор тус тус өсжээ. Бүхэл үрийн гурил 420 тн үйлдвэрлэсэн байна.

Зураг 4. Гурилын үйлдвэрлэл нэр төрөл, мянган тонноор



#### Архи, ус, ундаа үйлдвэрлэл

2018 онд цэвэр спирт, архи, ус, ундаа үйлдвэрлэдэг үйлдвэрүүд 48330.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 9719.7 (25.2%) сая төгрөгөөр өссөн байна. 2018 онд цэвэр спирт, архи, ус, ундаа үйлдвэрлэдэг үйлдвэрүүд цэвэр спирт 1902.3 мян.л үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 650.3 (51.9%) мян.л-ээр, пиво 1522.08 мян.л үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 407.5 (36.5%) мян.л-ээр, цэвэр ус 12859.8 мян.л үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 2104.2(19.5%) мян.л-ээр, архи 4539.5 мян.л үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 849.4 (23.0%) мян.л-ээр өссөн байна.

#### Хүснэгт 2. Архи, ус, ундаа үйлдвэрлэл, мянган литрээр

Бүтээгдэхүүн	2016	2017	2018	$\frac{2018}{2017}$ %
Цэвэр спирт	1120.4	1252	1902.3	151.9
Архи	4496.3	3690.1	4539.5	123.0
Пиво	1042.6	1114.5	1522.0	136.5
Цэвэр ус	10622.6	10755.6	12859.8	119.5

#### ХҮНСНИЙ БУС БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ


2018 онд хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрүүд 34777.9 сая төгрөгийн хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 13067.0 (60.2%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт үйлдвэрлэлийн 6553.0 (1.3%) сая төгрөгийг хувцас, 16802.6 (3.4%) сая төгрөгийг химийн бүтээгдэхүүн, 283.6 (0.1%) сая төгрөгийг резинен болон хуванцар бүтээгдэхүүн, 8783.3 (1.8%) сая төгрөгийг төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл, 2125.5 (04%) сая төгрөгийг машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл, 229.4 (0.05%) сая төгрөгийг мебель тавилга үйлдвэрлэл тус тус эзэлж байна.

2018 онд хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрийн газрууд 96.1 мянган ширхэг хувцас үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 42.1 (78%) мянган ширхэгээр, 8581.6 мянган ширхэг эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 1807.6 (26.7%) мянган ширхэгээр, 644.9 мянган ширхэг хөнгөн блок үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 459.5 (3.4 дахин) мянган ширхэгээр, 2625.4 ширхэг машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 424.1 (19.3%) ширхэгээр тус тус өссөн байна. Харин 917.8 тн химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 69.3(7%) тонноор, 1800 метр куб төмөр бетон эдлэл үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 100 (5.3%) метр куб-ээр, 7.2 метр.кв төмөр хаалга цонх үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 4.8 (40%) метр квадратаар тус тус буурсан байна.

### Хүснэгт 3. Хүнсний бус бүтээгдэхүүн, нэр төрлөөр

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2017	2018	$\frac{2018}{2017}$ %
Хувцас	мян.ш	54	96.1	178.0
Мод, модон эдлэл	ширхэг	162.2	-	0
Эмийн бүтээгдэхүүн	мян.ш	6774	8581.6	126.7
Химийн бүтээгдэхүүн	тн	987.1	917.8	93.0
Хөнгөн блок	мян.ш	185.4	644.9	3.4 дахин
Төмөр бетон эдлэл	метр куб	1900	1800	94.7
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	ширхэг	2201.3	2625.4	119.3
Төмөр хаалга цонх	метр.кв	12	7.2	60.0

### Зураг 5. Хүнсний бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сая төгрөгөөр



### АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ

2018 онд аж үйлдвэрийн газрууд нийт 489814.8 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос 139466.5 (39.8%) сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс мах, махан бүтээгдэхүүн 78831.3 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос 47789.4 (2.5 дахин) сая төгрөг, сүү, сүүн бүтээгдэхүүн 137830.8 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос 45494.4 (49.2%) сая төгрөгөөр, үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн 94171.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос 8407.6 (9.8%) сая төгрөгөөр, хүнсний бусад бүтээгдэхүүн 57021.5 сая төгрөгийн




борлуулалт хийсэн нь өмнөх оноос 10769.3 (23.2%) сая төгрөгөөр, архи, ус, ундаа 87393.1 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос 17591.2 (25.2%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 4. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017	2018	$\frac{2018}{2017}$ %
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>350348.3</b>	<b>489814.8</b>	<b>139.8</b>
<b>Хүнсний бүтээгдэхүүн, архи ус, ундаа үйлдвэрлэл</b>	<b>325196.1</b>	<b>455248.1</b>	<b>140.0</b>
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	31041.9	78831.3	2.5 дахин
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	92336.4	137830.8	149.3
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	85763.8	94171.4	109.8
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	46252.2	57021.5	123.3
Архи, ус, ундаа үйлдвэрлэл	69801.9	87393.1	125.2
<b>Хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэл</b>	<b>25152.1</b>	<b>34566.7</b>	<b>137.4</b>
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	5664.3	7002.6	123.6
Мод, модон эдлэл	89.7	0	0.0
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	12618	16226.4	128.6
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	219.9	283.6	129.0
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	3262.9	8524.4	2.6 дахин
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	2880.8	2256.2	78.3
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	416.5	273.5	65.7

Хүнсний бус бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрүүд 2018 онд нийт 34566.7 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос 9414.6 (37.4%) сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс 7002.6 сая төгрөгийн хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулдаг үйлдвэрүүд борлуулалт хийсэн нь өмнөх оноос 1338.3 (23.6%) сая төгрөгөөр, 16226.4 сая төгрөгийн химийн бүтээгдэхүүний борлуулалт хийсэн нь өмнөх оноос 3608.4 (28.6%) сая төгрөгөөр, 8524.4 сая төгрөгийн төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэлийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос 5261.5 (2.6 дахин) сая төгрөгөөр, 283.6 сая төгрөгийн резинен болон хуванцар бүтээгдэхүүний борлуулалт хийсэн нь өмнөх оноос 63.7 (29%) сая төгрөгөөр өссөн байна. Харин 2256.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэлийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос 624.6 (21.7%) сая төгрөгөөр, 273.5 сая төгрөгийн мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад бүтээгдэхүүний борлуулалт хийсэн нь өмнөх оноос 143 (34.3%) сая төгрөгөөр буурсан байна.

Зураг 6. Хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт, сая төгрөгөөр



2018 онд аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрүүд гадаадын зах зээлд нийт 45548.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Үүнээс 42993.6 сая төгрөгийн мах, махан бүтээгдэхүүний, 923 сая төгрөгийн архи, ус, ундааны, 1631.8 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэлийн бүтээгдэхүүн тус тус гадаадын зах зээлд нийлүүлсэн байна. Экспорт нь нийт борлуулалтын 9.3 хувийг эзэлж байна.

Зураг 7. Экспорт, дэд салбараар, сая төгрөгөөр



Танилцуулга бэлтгэсэн:  
Мэргэжилтэн Б.Лхагвасайхан